



МАСКАА ЗҮҮЕ



ГАРАА УГААЯ



ЗАЙГАА БАРЬЯ



УСНЫ САЛБАРЫН ЭРГЭН ТОЙРОНД



MILLENNIUM
CHALLENGE CORPORATION
UNITED STATES OF AMERICA

Долоо хоног тутмын мэдээ мэдээлэл - Монголын Мянганы сорилтын сан

№2 (01)

2021.01.04

УСНЫ ТӨЛБӨРИЙН ХӨНГӨЛӨЛТӨД 720 ГАРУЙ МЯНГАН ӨРХ ХАМРАГДАНА



Монгол Улсын Засгийн газар цар тахлын хүнд үед иргэдийн амжиргааг дэмжих, аж ахуйн нэгжүүдэд ажлын байраа хадгалахад дэмжлэг болгох зорилгоор улсын хэмжээнд бүх айл өрх, зарим аж ахуйн нэгжийн цахилгаан, дулаан, ус, хогны төлбөрийг 2021 оны долдугаар сар хүртэл чөлөөлөх шийдвэр гаргасан билээ. Энэ арга хэмжээний хүрээнд нийт 720 гаруй мянган айл өрх усны төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдах тооцоо гарчээ. Эдгээр айл өрхөөс 340 мянга нь төвийн шугамд холбогдсон бол 380 гаруй мянга нь зөөврийн ус хэрэглэж байна. Одоогоор төлбөр чөлөөлсөнтэй холбоотойгоор айл, өрх аж ахуйн нэгжийн усны хэрэглээ өссөн тохиолдол гараагүй байгаа бөгөөд цаашид хэрэглээ

нэмэгдсэн тохиолдолд илүү гарсан хэрэглээг хэрхэх талаар цаг тухайд нь хэлэлцэн шийдвэр гаргаж, шаардлагатай бол зохицуулалт хийнэ гэж Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дарга Ж.Батсуурь ММ агентлагт мэдээлжээ.

[Эх сурвалж: https://mnb.mn/](https://mnb.mn/)

ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙН ГУРАВДУГААР ҮЕ ШАТНЫ ТӨСЛИЙН ХҮРЭЭНД 50 ОРЧИМ КМ ЦЭВЭР, БОХИРЫН ШУГАМ БАРИНА



“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн гуравдугаар үе шатны төслийн хүрээнд Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулах зээлийн хэлэлцээрүүдийн төслийг Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 30-ны ээлжит хуралдаанаар хэлэлцэж, Зээлийн хэлэлцээрүүдэд гарын үсэг зурах эрхийг Сангийн сайдад олгожээ. 2020-2023 онд хэрэгжих гуравдугаар үе шатны төслийн нийт хөрөнгө оруулалтын 43,6 сая ам.долларыг Азийн хөгжлийн банкнаас үлдсэн хэсгийн Европын хөрөнгө оруулалтын банк болон НЗДТГ-аас санхүүжүүлэх бөгөөд төслийн Шархад болон Толгойт дэд төвийг бүтээн байгуулж, энэ хүрээнд Шархад дэд төвд цэвэр усны 8.1 км, бохир усны 7.8 км шугам, Толгойт дэд төвд цэвэр усны 26 км, бохир усны 6 км шугамыг шинээр барих юм.

[Эх сурвалж: zasaq.mn](https://zasaq.mn)

НҮБ БОЛОН КОЙКА-ГИЙН ХӨТӨЛБӨРИЙН ДЭМЖЛЭГЭЭР НЭГ ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙЖЭЭ



2020 онд НҮБ-ын Хүүхдийн сан, БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага КОЙКА-гийн дэмжлэгээр 1,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, эрчим хүчний хэмнэлттэй, шинэлэг шийдэл бүхий ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламж засвар шинэчлэлтийн ажлуудыг хийж гүйцэтгэжээ.

Тухайлбал, тус аймгийн хүн амын усан хангамжийг сайжруулах зорилгоор Дарви, Алтай, Төгрөг, Есөнбулаг, Шарга суманд зөөврийн усан сан бүхий байгууламж, засвар шинэчлэлт, ухаалаг төхөөрөмж, хайс хамгаалалтын ажил, Жаргалан, Эрдэнэ, Бугат суманд халуун усны газар, Цогт, Баян-Уул, Нэгдсэн эмнэлгийн Хүүхдийн тасаг, “Марал-Алтай” ӨЭМТ, Есөнбулаг дөрөвдүгээр цэцэрлэг, “Хантайшир-Эрдэм цогцолбор” сургууль, Гуулин тосгоны ЕБС гэх мэт эрүүл мэндийн байгууллага, сургууль, цэцэрлэгүүдэд гадна, дотор ариун цэврийн байгууламжийн засвар шинэчлэлтийн ажлыг хийсэн байна. Түүнчлэн Төгрөг, Дарви, Эрдэнэ, Есөнбулаг суманд өрхийн, 14 суманд малчин өрхийн ариун цэврийн байгууламж байгууллаа хэмээн Говь-Алтай аймгийн ЗДТГ-аас мэдээлжээ

[Эх сурвалж: montsame.mn](https://montsame.mn)

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ БҮТЭЭЛ

“ХҮНЦЭЛ (III)-ИЙГ ИСЭЛДҮҮЛЭН ТУНАДАСЖУУЛАХ АРГААР ХАЯГДАЛ УС ЗАЙЛУУЛАХ ШИНЭ ТЕХНОЛОГИ” БҮТЭЭЛЭЭР ШИЛДЭГ ЗАЛУУ ЭРДЭМТЭН БОЛЛОО



Залуучуудыг ажил хөдөлмөр, бүтээлч үйлдвэрлэл, шинжлэх ухаанч хөгжилд уриалах, залуу үеийн мэргэжлийн боловсрол, ур чадвар, мэргэшсэн боловсон хүчний бодлогыг дэмжих зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит шагнал олгодог журамтай. Энэхүү журмын дагуу Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит 2020 оны шагналыг хүртээх тухай зарлиг гаргаж, Шинжлэх ухааны Академийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор Отгоны Насантогтох “Хүнцэл (III)-ийг исэлдүүлэн тунадасжуулах аргаар хаягдал ус зайлуулах шинэ технологи” сэдэвт судалгааны бүтээлээрээ Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит “Шилдэг залуу эрдэмтэн” шагналыг хүртлээ. Тэрээр “Энэ бүтээлээ сайжруулах

чиглэлээр ойрын таван жилдээ олон зүйл хийнэ, хэрэглээнд нэвтрүүлэхэд бэлэн болгоно гэсэн төлөвлөгөө бий. Монголд судлагдах боломжгүйг нь гадаад руу явж судална. Үйлдвэрлэлийн гаргалгааг тогтоож олно” гэжээ.

[Эх сурвалж: president.mn](https://president.mn), ergelt.mn